



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хангал сумын Хялганат тосгоны захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2026/034/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт Утас: 70342716 Цахим хаяг: battsogtd@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Ахлах аудитор: П.Содном Утас: 70342495 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

8026.02.16 № 90

танай _____ ны № _____ т

ХАНГАЛ СУМЫН ХЯЛГАНАТ
ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН
АЛБАНЫ ДАРГА Ч.НОМИН-ЭРДЭНЭ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хангал сумын Хялганат тосгоны захирагчийн ажлын албаны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хангал сумын Хялганат тосгоны захирагчийн ажлын албаны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Хялганат тосгон нь тайлант онд 50 жилийн ойн баярыг зохион байгуулсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн "Цаст хан хөхий" ХХК-тай хогны авто машины кабин нийлүүлэх гэрээг 10.0 сая төгрөгөөр байгуулж, урьдчилгаа 7.0 сая төгрөгийг олгож барааг хүлээн аваагүй, авлагаар тусгаж тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Хангал сумын Хялганат тосгоны захирагчийн ажлын алба нь 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 5 зорилт 44 арга хэмжээний хэрэгжилт 82.1 хувиар дүгнэсэн,

8026050006

хөтөлбөр арга хэмжээнд зориулан 1,163.3 сая төгрөгийг төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1,137.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хангал сумын Хялганат тосгоны захирагчийн ажлын алба нь 2025 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>459,615,045.40</u>	<u>142,530,861.21</u>
АВЛАГА	-	67,192,689.81
Ажиллагчидтай холбогдсон авлага	-	192,689.81
Бусад авлага	-	67,000,000.00
Байгууллагаас авах авлага	-	67,000,000.00
БАРАА МАТЕРИАЛ	66,126,069.40	75,338,171.40
Түүхий эд материал	6,827,219.40	15,149,719.40
Тусгай зориулалттай материал	6,827,219.40	15,149,719.40
Хангамжийн материал	59,298,850.00	60,188,452.00
Бичиг хэргийн материал	1,346,850.00	1,526,850.00
Аж ахуйн материал	8,843,000.00	12,784,900.00
Бусад хангамжийн материал	49,109,000.00	45,876,702.00
НӨӨЦИЙН БАРАА	393,488,976.00	-
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	393,488,976.00	-
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,536,574,167.11</u>	<u>6,320,045,024.32</u>
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,536,574,167.11	6,320,045,024.32
Биет хөрөнгө	5,281,932,167.11	6,065,403,024.32
Барилга, байгууламж, орон сууц	2,166,155,985.01	2,641,257,985.01
Хуримтлагдсан элэгдэл	(190,220,069.57)	(264,510,334.20)
Авто-тээврийн хэрэгсэл	288,660,000.00	396,060,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(66,192,888.49)	(118,650,555.00)
Машин тоног төхөөрөмж (компьютер)	730,086,321.88	934,524,144.14
Хуримтлагдсан элэгдэл	(208,439,444.76)	(270,226,852.19)
Тавилга, аж ахуйн эд хогшил	89,456,862.00	88,153,818.00
Хуримтлагдсан элэгдэл	(19,385,394.53)	(25,923,032.69)
Бусад үндсэн хөрөнгө	3,271,164,560.85	3,596,331,388.09
Хуримтлагдсан элэгдэл	(840,013,165.28)	(972,272,936.84)
Ном	60,659,400.00	60,659,400.00

Биет бус хөрөнгө	254,642,000.00	254,642,000.00
Програм хангамж	2,100,000.00	2,100,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(2,100,000.00)	(2,100,000.00)
Бусад биет бус хөрөнгө	254,642,000.00	254,642,000.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,996,189,212.51</u>	<u>6,462,575,885.53</u>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>770,000.00</u>
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	770,000.00
Өглөг	-	770,000.00
Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	770,000.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,996,189,212.51</u>	<u>6,461,805,885.53</u>
Засгийн газрын хувь оролцоо	5,996,189,212.51	6,461,805,885.53
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	491,549,989.50	491,549,989.50
Хуримтлагдсан үр дүн	5,404,873,741.57	5,870,490,414.59
Өмнөх үеийн үр дүн	5,404,873,741.57	5,404,873,741.57
Тайлант үеийн үр дүн	-	465,616,673.02
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	99,765,481.44	99,765,481.44
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>5,996,189,212.51</u>	<u>6,462,575,885.53</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,718,665,236.62	2,344,139,501.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	716,766,036.62	1,179,621,582.00
Нийтлэг татварын бус орлого	716,766,036.62	1,179,621,582.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	694,693,273.38	1,172,598,280.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	41,612,883.38	35,829,704.62
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Үндсэн хөрөнгө	653,080,390.00	1,136,768,575.38
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	11,675,000.00	7,023,302.00
Бусад орлого	10,397,763.24	-
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,001,899,200.00	1,164,517,919.00

Нэмэлт санхүүжилтийн орлого	32,788,500.00	858,645.00
ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,984,500.00	150,000.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,804,000.00	708,645.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	969,110,700.00	1,163,659,274.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	969,110,700.00	1,163,659,274.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,371,257,099.24	1,878,522,827.98
УРСГАЛ ЗАРДАЛ	1,371,257,099.24	1,878,522,827.98
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,330,296,591.89	1,819,081,440.04
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	480,320,171.16	571,035,770.05
Үндсэн цалин	264,246,092.16	309,244,575.00
Нэмэгдэл	149,619,979.00	211,880,195.55
Унаа хоолны хөнгөлөлт	34,010,000.00	17,905,000.00
Урамшуулал	32,444,100.00	32,005,999.50
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,275,338.46	71,615,355.19
Тэтгэврийн даатгал	41,857,627.71	48,384,918.42
Тэтгэмжийн даатгал	4,859,220.58	5,527,300.70
ҮОМШӨ-ний даатгал	3,595,133.70	3,923,684.26
Ажилгүйдлийн даатгал	2,392,671.32	2,739,890.38
Эрүүл мэндийн даатгал	9,570,685.15	11,039,561.43
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	231,432,720.41	237,767,398.63
Гэрэл, цахилгаан	27,889,672.80	40,379,812.62
Түлш, халаалт	190,663,047.61	194,677,786.01
Цэвэр, бохир ус	12,880,000.00	2,709,800.00
Хангамж, бараа материалын зардал	28,979,470.00	433,478,141.00
Бичиг хэрэг	3,498,570.00	4,246,700.00
Тээвэр, шатахуун	14,701,000.00	18,425,665.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,450,400.00	2,368,400.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,414,500.00	7,275,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,915,000.00	5,546,300.00

Бараа материал акталсны зардал	-	395,616,076.00
Нормативт зардал	800,000.00	1,545,900.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	1,545,900.00
Эд хогшил, урсгал засварын зардал	22,132,000.00	45,234,110.00
Багаж, техник, хэрэгсэл	352,000.00	-
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	741,600.00
Урсгал засвар	21,780,000.00	44,492,510.00
Томилолт, зочны зардал	29,293,876.00	6,700,800.00
Гадаад албан томилолт	21,650,000.00	-
Дотоод албан томилолт	7,643,876.00	6,700,800.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,789,860.00	13,733,640.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,432,300.00	11,846,000.00
Даатгалын үйлчилгээ	224,300.00	-
Тээврийн хэрэгслийн татвар	212,260.00	327,640.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	-
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	450,000.00
Газрын төлбөр	800,000.00	1,110,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	445,273,155.86	437,970,325.17
Бараа үйлчилгээний бусад зардал	112,198,223.24	75,613,607.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,879,100.00	199,000.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	329,195,832.62	362,157,718.17
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,960,507.35	59,441,387.94
Бусад урсгал шилжүүлэг	29,373,976.00	56,997,156.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	13,644,000.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	43,353,156.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	27,873,976.00	-
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	-
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,586,531.35	2,444,231.94
Төвлөрүүлэх шилжүүлэг	11,586,531.35	2,444,231.94
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	347,408,137.38	465,616,673.02

НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)

347,408,137.38465,616,673.02**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан****/төгрөгөөр/**

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,053,909,846.62	1,200,347,623.62
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	52,010,646.62	35,829,704.62
Нийтлэг татварын бус орлого	52,010,646.62	35,829,704.62
Төсөв байгууллагын өөрийн орлого	41,612,883.38	35,829,704.62
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	41,612,883.38	35,829,704.62
Бусад орлого	10,397,763.24	-
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,001,899,200.00	1,164,517,919.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	32,788,500.00	858,645.00
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,984,500.00	150,000.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,804,000.00	708,645.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	969,110,700.00	1,163,659,274.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	969,110,700.00	1,163,659,274.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,022,720,146.62	1,191,487,623.62
УРСГАЛ ЗАРДАЛ	1,022,720,146.62	1,191,487,623.62
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	981,759,639.27	1,072,046,235.68
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	480,494,833.16	571,035,770.05
Үндсэн цалин	264,831,341.47	309,244,575.00
Нэмэгдэл	149,319,979.00	211,880,195.55
Унаа хоолны хөнгөлөлт	34,010,000.00	17,905,000.00
Урамшуулал	32,333,512.69	32,005,999.50
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,100,676.46	71,808,045.00
Тэтгэврийн даатгал	41,682,965.70	48,577,608.23
Тэтгэмжийн даатгал	4,859,220.58	5,527,300.70
ҮОМШӨ-ний даатгал	3,994,140.62	3,923,684.26

Ажилгүйдлийн даатгал	2,503,814.24	2,739,890.38
Эрүүл мэндийн даатгал	9,060,535.32	11,039,561.43
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	231,432,720.41	237,767,398.63
Гэрэл, цахилгаан	27,889,672.80	40,379,812.62
Түлш, халаалт	190,663,047.61	194,677,786.01
Цэвэр, бохир ус	12,880,000.00	2,709,800.00
Хангамж, бараа материалын зардал	28,401,400.00	45,042,065.00
Бичиг хэрэг	3,000,000.00	4,426,700.00
Тээвэр, шатахуун	14,701,000.00	18,425,665.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,450,400.00	2,368,400.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,000,000.00	14,275,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,250,000.00	5,546,300.00
Нормативт зардал	800,000.00	2,249,900.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	2,249,900.00
Эд хогшил, урсгал засварын зардал	22,542,000.00	46,492,510.00
Багаж, техник, хэрэгсэл	422,000.00	-
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	2,000,000.00
Урсгал засвар	22,120,000.00	44,492,510.00
Томилолт, зочны зардал	29,293,876.00	5,930,800.00
Гадаад албан томилолт	21,650,000.00	-
Дотоод албан томилолт	7,643,876.00	5,930,800.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,091,060.00	13,733,640.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,733,500.00	11,846,000.00
Даатгалын үйлчилгээ	224,300.00	-
Тээврийн хэрэгслийн татвар	212,260.00	327,640.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	-
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	450,000.00
Газрын төлбөр	800,000.00	1,110,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	97,603,073.24	77,986,107.00
Бараа үйлчилгээний бусад зардал	93,723,973.24	77,787,107.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,879,100.00	199,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,960,507.35	119,441,387.94

Бусад урсгал шилжүүлэг	29,373,976.00	56,997,156.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	13,644,000.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	43,353,156.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	27,873,976.00	-
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	-
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,586,531.35	2,444,231.94
Төвлөрүүлэх шилжүүлэг	11,586,531.35	2,444,231.94
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	60,000,000.00
Төвлөрүүлэх шилжүүлэг		60,000,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>31,189,700.00</u>	<u>8,860,000.00</u>
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	31,189,700.00	8,860,000.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	31,189,700.00	8,860,000.00
Дотоод эх үүсвэрээр	31,189,700.00	8,860,000.00
Тоног төхөөрөмж	31,189,700.00	8,860,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(31,189,700.00)</u>	<u>(8,860,000.00)</u>
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>-</u>	<u>-</u>
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	491,549,989.50	99,765,481.44	5,057,465,604.19	5,648,781,075.13
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	491,549,989.50	99,765,481.44	5,057,465,604.19	5,648,781,075.13
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	347,408,137.38	347,408,137.38
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	491,549,989.50	99,765,481.44	5,404,873,741.57	5,996,189,212.51
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	491,549,989.50	99,765,481.44	5,404,873,741.57	5,996,189,212.51
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	491,549,989.50	99,765,481.44	5,404,873,741.57	5,996,189,212.51
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	465,616,673.02	465,616,673.02
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	491,549,989.50	99,765,481.44	5,870,490,414.59	6,461,805,885.53

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,164,493,700.00	1,137,044,746.68
УРСГАЛ ЗАРДАЛ	1,164,493,700.00	1137044746.68
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,105,474,900.00	1080047590.68
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	570,786,400.00	570692770.05
Үндсэн цалин	281,365,700.00	309244575.00
Нэмэгдэл	217,830,200.00	211537195.55
Унаа хоолны хөнгөлөлт	24,908,000.00	17905000.00
Урамшуулал	46,682,500.00	32005999.50
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,344,400.00	71768600.00
Тэтгэврийн даатгал	48,516,800.00	48538163.23
Тэтгэмжийн даатгал	4,566,500.00	5527300.70
ҮОМШӨ-ний даатгал	5,707,900.00	3923684.26
Ажилгүйдлийн даатгал	1,137,500.00	2739890.38
Эрүүл мэндийн даатгал	11,415,700.00	11039561.43
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	239,366,900.00	237767398.63
Гэрэл, цахилгаан	41,000,000.00	40379812.62
Түлш, халаалт	195,657,100.00	194677786.01
Цэвэр, бохир ус	2,709,800.00	2709800.00
Хангамж, бараа материалын зардал	52,210,900.00	44795865.00
Бичиг хэрэг	6,181,000.00	4426700.00
Тээвэр, шатахуун	18,949,600.00	17949465.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,386,000.00	2,368,400.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	18,000,000.00	14,275,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,694,300.00	5,776,300.00
Нормативт зардал	3,000,000.00	2,249,900.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,000,000.00	2,249,900.00
Эд хогшил, урсгал засварын зардал	62,230,000.00	55,122,510.00
Багаж, техник, хэрэгсэл	8,350,000.00	8,250,000.00
Тавилга	380,000.00	380,000.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,000,000.00	2,000,000.00
Урсгал засвар	51,500,000.00	44,492,510.00
Томилолт, зочны зардал	7,000,000.00	5,930,800.00
Дотоод албан томилолт	7,000,000.00	5,930,800.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,460,000.00	13,733,640.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,200,000.00	11,846,000.00
Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	327,640.00

Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	450,000.00
Газрын төлбөр	1,410,000.00	1,110,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	85,076,300.00	77,986,107.00
Бараа үйлчилгээний бусад зардал	84,876,300.00	77,787,107.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200,000.00	199,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,018,800.00	56,997,156.00
Бусад урсгал шилжүүлэг	59,018,800.00	56,997,156.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,644,000.00	13,644,000.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	43,374,800.00	43,353,156.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,164,493,500.00	1,137,044,746.68
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,139,493,500.00	1,101,215,042.06
Орон нутгийн төсвөөс	1,139,493,500.00	1,101,215,042.06
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	25,000,000.00	35,829,704.62
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,000,000.00	35,829,704.62
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
Төсвийн байгууллага	1.00	1.00
АЖИЛЛАГСАДЫН ТОО	14.00	16.00
Удирдах ажилтан	2.00	-
Гүйцэтгэх ажилтан	9.00	9.00
Үйлчлэх ажилтан	3.00	3.00
Гэрээт ажилтан	-	4.00
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	18.00	18.00
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	6.00	6.00
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9.00	9.00
Улс төрийн албан хаагч (УТ)	3.00	3.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	858,645.00
УРСГАЛ ЗАРДАЛ	-	858,645.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	858,645.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	343,000.00
Нэмэгдэл	-	343,000.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	39,445.00
Тэтгэврийн даатгал	-	39,445.00
Хангамж, бараа материалын зардал	-	476,200.00
Тээвэр, шатахуун	-	476,200.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	858,645.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	858,645.00
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	150,000.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	708,645.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 161,476.7 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн жилийн элэгдлийг 141,476.7 мянган төгрөгөөр илүү тооцон үр дүнгийн тайланд тусгасан,
- Байгал хамгаалах сангаас тосгоны цагдаагийн тасагт хяналт шалгалт хийх зориулалтаар 20,000.0 мянган төгрөгийн автомашины худалдан авсныг орлогод аваагүй,

Аудитаар нийт 80439.2 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 3,948.1 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт, 7,000.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 69,491.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

3.1 Төлбөрийн акт

- Тосгоны захирагчийн 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн Б/19 дүгээр захирамжаар Ч.Номин-Эрдэнэд 222,861.00 (хоёр зуун хорин хоёр мянга найман зуун жаран нэг), П.Сэржмядаг 204382 (хоёр зуун дөрвөн мянга гурван зуун наян хоёр) төгрөгийн урамшууллыг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн аймгийн Засаг даргын захирамжийг үндэслэн нийт 427,243.00 (дөрвөн зуун хорин долоон мянга хоёр зуун дөчин гурван) төгрөгийн урамшуулал олгосон.
- Захирагчийн ажлын албаны даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн Б/42 тушаалаар гамшгаас хамгаалах ажлыг архив бичиг хэргийн эрхлэгч П.Сэржмядагт хавсруулан 40 хувийн нэмэгдэл олгож, 2025 оны 8 дугаар сараас гамшгаас хамгаалах ажил байгаль орчны улсын байцаагчийн ажлын байрны тодорхойлолтод тусгаж баталсан байхад нэмэгдлийг үргэлжлүүлэн олгож 2,043,819 (хоёр сая дөчин гурван мянга найман зуун арван ёс) төгрөгийг илүү олгосон байна.
- Захирагчийн ажлын албаны 13 ажилтан албан хаагчдад хөдөлмөр хамгааллын зардлаас 1,258,400.00 (нэг сая хоёр зуун тавин найман мянга) төгрөгийн ажлын хантааз авсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "*Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно.*" гэсэн заалттай нийцэхгүй байна.
- Захирагчийн 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн Б/15 дугаар захирамжаар төсөв, төрийн сангийн мэргэжилтэн А.Гэрэлтуяад санхүүгийн албаны даргын ажлыг түр орлон гүйцэтгүүлэх тушаалыг гаргаж 40 хувийн нэмэгдэл олгож, 218,662 (хоёр зуун арван найман мянга зургаан зуун жаран хоёр) төгрөгийг илүү олгосон байна.

3.2 Албан шаардлага

- "Цаст хан хөхий" ХХК-тай хогны авто машины кабин нийлүүлэх гэрээг 10,000,000.0 (арван сая) төгрөгөөр байгуулж, урьдчилгааг 7,000,000.00 (долоон сая) төгрөгийг олгож ажлыг хүлээн аваагүй, авлагаар тусгаж тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

3.3 ЗӨВЛӨМЖ:

Зардлын данстай холбоотой

Илрүүлэлт 1: Багаж техник хэрэгслийн зардлаас 8250.0 мянган төгрөг 2 компьютер, 1 хурдан скайнар шууд худалдан авалт хийсэн

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-д "Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Зөвлөмж: Багаж, техник хэрэгслийг худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан авалт хийж байх.

Үндсэн хөрөнгийн данстай холбоотой

Илрүүлэлт 2: Анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн хөрөнгө 66 нэр төрлийн 61,241.0 төгрөгийн хөрөнгийг данснаас хасах, үнэ шинэчлэн тогтоох ажлыг зохион байгуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.3.3 дахь " засаж сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах;", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын хорооны 271 тоот тогтоолоор баталсан 7.1-д заасан "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийг ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Зөвлөмж: Хөрөнгийн үнэ шинэчлэн тогтоох, актлах хүсэлтийг холбогдох байгууллагад хүргүүлж, гарсан шийдвэрийн дагуу хөдөлгөөн өөрчлөлтийг хийх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				
							Үүнээс		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		Тоо	
Үндсэн хөрөнгийн жилийн элэгдлийг 141476.7 мянган төгрөгөөр илүү тооцон үрдүнгийн тайланд тусгасан	1	141,476.7	1	141,476.7			1	141,476.7			0.0
Байгал хамгаалах сангаас тосгоны цагдаагийн тасагт хяналт шалгалт хийх зориулалтаар 20,000.0 мянган төгрөгийн автомашиныг орлогод аваагүй	1	20,000.0	1	20,000.0			1	20,000.0			
Дүн	2	161,476.7	2	161,476.7			2	161,476.7			

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хөдөлмөр хамгааллын зардлаас Захирагчийн ажлын албаны 13 албан хаагчид ажлын хантааз авахад 1258.4 мянган төгрөгийг зарцуулсан	1	1258.4	1	1258.4								

Захирагчийн ажлын албаны даргын 2024 оны 12 дугаар сарын 02 дугаар сарын Б/42 тушаалаар гамшгаас хамгаалах ажлыг архив бичиг хэргийн эрхлэгч П.Сэржмядагт 40 хувиар нэмэгдэл 2043.8 мянган төгрөгийг олгосон	1	4043.8	1	4043.8								
Захирагчийн 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн Б/15 дугаар захирамжаар төсөв төрийн сангийн мэргэжилтэн А.Гэрэлтуяад Санхүүгийн албаны даргын ажлыг түр орлон гүйцэтгүүлэх тушаалыг гаргаж 40 хувийн нэмэгдэл олгосон	1	218.7	1	218.7								
Тосгоны захирагчийн 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн Б/19 дүгээр захирамжаар гамшгаас хамгаалах их бүрэн сургууллт, тосгоны хэмжээнд ивэдхи санаачлага гарган ажилласанд Ч.Номин-Эрдэнэ (222861), П.Сэржмядаг (204382) нарт өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн аймгийн Засаг даргын захирамжийг үндэслэн 427243 төгрөгийн урамшуулал олгосон.	1	427.2	1	427.2								
"Цаст хан хөхий" ХХК-тай хогны авто машины кабин нийлүүлэх гэрээг 10,000.0 мянган төгрөгөөр байгуулж, урьдчилгааг 7000.0 мянган төгрөгийг олгож ажлыг хүлээн аваагүй, авлагаар тусгаж тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	1	7000.0			1	7000.0						

Багаж техник хэрэгслийн зардлаас 8250.0 мянган төгрөг 2 компьютер, 1 хурдан скайнар шууд худалдан авалт хийсэн	1	8250.0					1	8250.0				
Анхы ертөгөө элэгдлээрээ нөхсөн хөрөнгө 66 нэр төрлийн 61,241.0 төгрөгийн хөрөнгийг данснаас хасах, үнэ шинэчлэн тогтоох ажлыг зохион байгуулаагүй	1	61,241.1					1	61,241.1				
Нийт дүн			4	3,948.1	1	7000.0	2	69,491.1				

-oOo-